



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/80

Сүхбаатар сум

“Хариуцлагатай-хэрэглэгч” цахим арга хэмжээ зохион байгуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", 30 дугаар зүйлийн 30.1.1, 39 дүгээр зүйлийн 39.1, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.2, 18.1.3, 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны “Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр батлах тухай” 233 дугаар тогтоолын 3.4, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1.23 дахь зорилт, аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн “Иргэний хөгжлийг дэмжих жил”, Олон Улсын хэрэглэгчийн эрхийг хамгаалах өдөр”-ийг угтан “Хариуцлагатай-хэрэглэгч” сэдэвт арга хэмжээг батлагдсан удирдамжийн дагуу 2020 оны 03 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл цахим орчинг ашиглан тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт даалгасугай.

2. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хууль тогтоомж, үндэсний хөтөлбөрийг сурталчлах гарын авлага, шторк, видео нэвтрүүлэг, постер, боршур зэргийг бэлтгэн цахим хэлбэрээр иргэд, хэрэглэгчид, аж ахуйн нэгж, байгууллагуудад хүргүүлж ажиллахыг сумдын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах болон үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах орон тооны бус зөвлөлүүдэд үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

C:\users\albanbichig2020\zahiramjA4.docx

430801255